

ХАМГААС ДЭЭД НЬ НИГҮҮЛСЭНГҮЙ СЭТГЭЛ БОЛОЙ

Амгалан ажрагсан бээр айлдахдаа:

“Бодьсадва бээр олон Номыг үл дагана.

Бодьсадва ганц л Номыг даган баримталсаар

Булт эрдмийг төгөлдөр болгоно.

Бурханы Номын цогц ийнхүү

Бодьсадва түүний атганд хурмуй” хэмээв. Тэр Ном нь юу вэ? Тэр бол их **НИГҮҮЛСЭНГҮЙ** сэтгэл юм. (*Сайтар хураасан Ном хэмээх Жанрайсигийн судраас*)

Бурханы шашныг бусад шашнаас ялгаж буй зүйл бол амьтан тус бүрийг ганцыг ч хоцроолгүй **НИГҮҮЛСЭХ** сэтгэл билээ.

Хамаг Бурхад, бодьсадва нарын тааллыг жинхэнээр баясагч нь **НИГҮҮЛСЭНГҮЙ** сэтгэл билээ.

НИГҮҮЛСЭНГҮЙ сэтгэлээр л хамаг амьтан амгалантай учирна.

Бодийн хутагт түргэнээ хүрэхийн үндэс суурь нь **ЧАНД ХАТУУ НИГҮҮЛСЭНГҮЙ** сэтгэл юм. Хэрэв та амьтан бүхнийг гаслан зовлонгоос ангижруулж, бурханы хутагт хөтлөхийн тухайтад бурхан болохыг хүсэмжилж буй бол хамгаас үгэр түргэн арга бол **НИГҮҮЛСЭХ** сэтгэлийг баттай төрүүлэх явдал билээ.

Чандрагирти бээр: “**НИГҮҮЛСЭНГҮЙ** бол эхэндээ хөрөнгө үр адил, дунд нь ус чийг мэт, эцэстээ боловсрох үр жимс лугаа адил билээ. Бодь хутгийн үрд хүрэх нь гагц **НИГҮҮЛСЭХҮЙ** сэтгэлээс үүднэ” хэмээн айлджээ.

Шашин шүтлэггүй хүмүүсийн хувьд ч мөн адил тохиолдлоор өргөл тахил өргөх, шүтээнд мөргөх, гороолох тэргүүтнээс гадна **НИГҮҮЛСЭХ** сэтгэл нь сайн үйл (буян) хураах хамгийн сайн бөгөөд цорын ганц зам болно. Амьтан бүхний амьдралыг жаргалтай, сэтгэл хангалуун, утга учиртай, амжилтаар дүүрэн болгогч нь **НИГҮҮЛСЭНГҮЙ** сэтгэл юм.

Лодой Жамцын айлтгасан судар-т:

“Бурхан болж гэгээрэхийг хүсэх,
Бодь Дээдийн Номыг хариулж хадгалах,
Бодитойгоор Номыг үйлдэх,
Бүхий л амьтныг асрамжлан нигүүлсэх
Бүхий эл дөрвөн номын тус эрдэм нь
Хэмжил цаглашгүй хийгээд
Хязгаарыг нь Ялж Төгс Нөгчигсөн

Хутагтан бурхад ч үл болгоосон гэдэг” хэмээжээ. Энэ нь хэрэв бид энгийн нүдээр үл үзэгдэх бичил амьтнаас авахуулаад уулын чинээ том биетэй амьтан бүхнийг **НИГҮҮЛСЭХ** сэтгэлийг төрүүлдээс тэрхүү сэтгэлийн буяны хязгаарыг Бурхан багш үл айлдсан гэсэн үг юм. Энэ нь хүмүүн, адгуус, хорхой шавьжны амийг аварсантай тэнцэх ба ач тус нь хязгаарлашгүй гэдгийг ухаарах хэрэгтэй.

Гаадамбын ёсны нэгэн гэвш: “Замбутивийн ариун төрөлхтөнүүд бээр аливаа хорлолыг гагц сайн үйлээр хариулна” хэмээжээ. Эгэл төрөлхтөнүүд хорлолын хариуд хорлол үзүүлнэ. Гэгээнтнүүд өөрт хорлосны хариуд ачлалыг үзүүлнэ. Дайсныг буяны саданд харсан хэн бээр ч, хаа ч байсан жаргалтай байдаг юм. Энэтхэгийн их бандид, бодьсадва Шантидэва **Бодьсадвын Явдалд Орохуй** - н эхний бүлэгтээ :

“Асралт сэтгэлийн дээд эрдэнэ тэр
Ашид баттай мэндэлсэн түүний лагшинаа мөргөмү
Алимад зовлонг үйлдсэн ч амгаланд барилдуудагч
Ашдын амгалан гарахын орон түүнээ итгэмой” хэмээжээ.

Хамаг амьтанд **ИХ НИГҮҮЛСЭХҮЙ**-г төрүүлэх нь бодь сэтгэл лугаа адил хязгааргүй огторгуй, хөлгүй далай мэт цаглашгүй их тус эрдэмтэй билээ. Их **НИГҮҮЛСЭНГҮЙ** сэтгэл үгүй бол энэхүү цаглашгүй туст бодь сэтгэлийг хэрхэн олох вэ.

Төгсгөлийг хураангуйлахад, **НИГҮҮЛСЭХҮЙ** бол амьдралдаа бүтээх хамгаас чухал үйл болно.

Энэхүү сургаалийг бидний үйл бүхэн гэгээрлийн уг шалтгаан болохын тухайтад айлджээ. Ялангуяа элдэв зовлон бэрхшээл тохиолдсон үед тухайн бэрхшээлтэй уялдуулан унших хэрэгтэй. Энэ бол хамгийн сайхан санаа бодол, авралт дээдийн Номын айлдвар хийгээд илааршуулагч сайн эм билээ.

Туурвин эмхтгэсэн Зопа Ринбүүчи ламтан, 2011 оны 8 дугаар сарын 11, Копан хийд.